



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 339

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-ийн эрх бүхий албан
тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Компанийн тухай хуулийн 84.1, Даатгалын тухай хуулийн 55.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захиралаар Даваахүү овогтой Болормаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Ганбаатар овогтой Саруул, Цэдэв овогтой Эрдэмбилэг, хараат бус гишүүнээр Жамбал овогтой Бат-Эрдэнэ, Даатгалын газрын захиралаар Батбаяр овогтой Хангай нарыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Д.Болормаа, Г.Саруул, Ц.Эрдэмбилэг, Ж.Бат-Эрдэнэ, Б.Хангай нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН